



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА  
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ховд аймгийн Үенч сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2023/156НА/-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Ховд хот  
2023 он

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Утас: 70433061

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Хоо өрлөгийн үрс - Аудит ХХК

Аудитор: А.Оюундэлгэр

Утас: 99306289

цахим хаяг: a\_oyund@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.5.1 Төсвийн төлөвлөлт.....	13
3.5.2 Төсвийн гүйцэтгэл .....	13
3.5.3 Нэмэлт төсөв .....	13
3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн .....	13
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал.....	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар.....	15
4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	15
5.1 Залруулсан алдаа.....	15
<i>Үндсэн хөрөнгөтэй холбоотой алдаа зөрчил гараагүй</i>	
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	16

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
БШУГ	Боловсрол шинжлэх ухааны газар



**ХОВД АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**  
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд  
Утас: 976-70433061, Факс: 976-70433061  
E-mail: khovd@audit.gov.mn

2023.02.14 № 02/36  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

ҮЕНЧ СУМЫН  
СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ  
Л.НЯМЖАРГАЛ ТАНАА

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Үенч сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Үенч сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

Боловсролын салбар төсвийн шинэчлэлийн хүрээнд цэцэрлэгийн санхүүгийн эрх мэдэл, хувьсах зардал, сургуулийн бүтэц, хэв шинжийн шинэчлэл, сургалтын чанарт суурилсан цалин урамшууллын тогтолцоог бий болгосон байна.

Багш нарын цалинг ТҮБД-4 ангиллаар олгосон, хувьсах зардлын тухайд багшийн эрүүл мэндийн үйлчилгээ, дата хэрэглээний зардал, хичээл практикийн зардал, багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийн зардлыг тусгаж, төлөвлөх, зарцуулах аргачлалыг Засгийн газрын 2022 оны 91 дугаар тогтоолоор баталж мөрдсөн байна.

#### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

#### Бусад асуудлын хэсэг

Тус сургууль нь 2022 онд нийт 760 хүүхэд сургах хүчин чадалтайгаас гүйцэтгэлээр 772 хүүхэд сургуулийн боловсролд хамруулж биелэлт 101.5 хувьтай байна.

021020008

Тус байгууллага нь тайлант онд 11 зорилтын хүрээнд хэрэгжүүлэх 22 арга хэмжээг хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, биелэлтийг 95.4 хувийн биелэлттэй гэж дүгнэсэн байна.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой. "

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>53,110,951.59</u></b>	<b><u>40,700,024.70</u></b>
31	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	00.00	968,122.40
312	<b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>	00.00	968,122.40
3121	<b>Төгрөг</b>	00.00	968,122.40
31211	Төрийн сангийн харилцах	00.00	968,122.40
33	<b>АВЛАГА</b>	13,518,203.59	824,454.30
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	518,203.59	824,454.30
335	<b>Бусад авлага</b>	13,000,000.00	00.00
3351	Байгууллагаас авах авлага	13,000,000.00	00.00
34	<b>УРЬДЧИЛГАА</b>	00.00	6,764,800.00
34600	Урьдчилж гарсан зардал	00.00	6,764,800.00
35	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	39,592,748.00	32,142,648.00
351	<b>Түүхий эд материал</b>	4,019,500.00	00.00
35130	Эм боох материал	4,019,500.00	00.00
354	<b>Хангамжийн материал</b>	35,573,248.00	32,142,648.00
35420	Аж ахуйн материал	3,500.00	00.00
35460	Хүнсний материал	6,434,000.00	3,006,900.00
35470	Бусад хангамжийн материал	29,135,748.00	29,135,748.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>3,198,746,825.90</u></b>	<b><u>3,308,965,997.58</u></b>
39	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	3,198,746,825.90	3,308,965,997.58
392	<b>Биет хөрөнгө</b>	3,078,746,825.90	3,188,965,997.58
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,357,258,589.00	3,478,861,181.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-420,080,855.08	-533,121,760.12
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,300,000.00	33,300,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-33,300,000.00	-33,300,000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	239,466,227.00	323,541,146.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-207,217,613.12	-206,107,863.48
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	192,896,858.42	210,621,756.82
39208	Хуримтлагдсан элэгдэл	-95,836,820.32	-97,088,902.64
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	8,000,000.00	8,000,000.00
39217	Ном	4,260,440.00	4,260,440.00
393	<b>Биет бус хөрөнгө</b>	120,000,000.00	120,000,000.00
39301	Програм хангамж	1,130,000.00	1,130,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,130,000.00	-1,130,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	120,000,000.00	120,000,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>3,251,857,777.49</u></b>	<b><u>3,349,666,022.28</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>00.00</u></b>	<b><u>1,040,377.99</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>00.00</b>	<b>1,040,377.99</b>
<b>413</b>	<b>Өглөг</b>	<b>00.00</b>	<b>1,040,377.99</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	00.00	1,040,377.99
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>3,251,857,777.49</u></b>	<b><u>3,348,625,644.29</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>3,251,857,777.49</b>	<b>3,348,625,644.29</b>
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	541,754,600.42	541,754,600.42

51101	Өмч: - төрийн	541,754,600.42	541,754,600.42
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>1,672,951,700.24</b>	<b>1,769,719,563.04</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	1,672,951,700.24	1,672,951,696.24
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	96,767,866.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,037,151,476.83	1,037,151,480.83
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>3,251,857,777.49</u></b>	<b><u>3,349,666,022.28</u></b>

## 2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1,279,432,555.00</b>	<b>2,166,673,965.65</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>29,125,052.00</b>	<b>278,852,038.40</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>29,125,052.00</b>	<b>180,284,928.40</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	29,125,052.00	180,284,928.40
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,595,900.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	29,125,052.00	174,289,028.40
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>00.00</b>	<b>98,567,110.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	98,567,110.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>90,034,703.00</b>	<b>362,319,527.25</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,160,272,800.00	1,525,502,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>36,913,543.00</b>	<b>00.00</b>
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	8,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,759,943.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,153,600.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>52,160,400.00</b>	<b>362,319,527.25</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,160,400.00	362,319,527.25
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>960,760.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	960,760.00	00.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,369,462,017.37</b>	<b>2,069,906,098.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,369,462,017.37</b>	<b>2,069,906,098.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,308,139,528.34</b>	<b>1,980,863,998.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>924,929,781.07</b>	<b>1,115,387,725.91</b>
210101	Үндсэн цалин	924,775,001.07	799,799,365.86
210102	Нэмэгдэл	154,780.00	251,634,291.80
210104	Урамшуулал	00.00	63,954,068.25
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>119,916,351.66</b>	<b>139,533,826.22</b>
210201	Тэтгэврийн даатгал	119,916,351.66	139,495,336.35
210202	Тэтгэмжийн даатгал	00.00	31,672.47
210203	ҮОМШӨ-ний даатгал	00.00	1,817.97
210204	Ажилгүйдлийн даатгал	00.00	454.49
210205	Эрүүл мэндийн даатгал	00.00	4,544.94
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>49,785,650.20</b>	<b>312,445,600.00</b>

210301	Гэрэл, цахилгаан	5,478,955.20	9,869,100.00
210302	Түлш, халаалт	44,306,695.00	302,226,500.00
210303	Цэвэр, бохир ус	00.00	350,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>7,724,937.00</b>	<b>00.00</b>
210401	Бичиг хэрэг	1,109,900.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,946,540.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	363,600.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,404,897.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,900,000.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>47,275,675.00</b>	<b>112,054,940.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	648,600.00	4,019,500.00
210502	Хоол, хүнс	44,165,575.00	108,035,440.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,461,500.00	00.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>354,000.00</b>	<b>00.00</b>
210702	Дотоод албан томилолт	354,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>6,960,000.00</b>	<b>112,500,810.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,240,000.00	102,163,010.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	10,337,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>151,193,133.41</b>	<b>188,941,096.72</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	15,720,534.85	41,594,400.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн даллага хийх	4,353,200.00	15,070,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	131,119,398.56	132,275,796.72
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,322,489.03</b>	<b>89,042,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51,218,034.00</b>	<b>89,042,100.00</b>
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	960,760.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,033,150.00	68,816,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,224,124.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	20,225,300.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	6,198,561.23	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,198,561.23	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>3,905,893.80</b>	<b>00.00</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,905,893.80	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>-90,029,462.37</b>	<b>96,767,866.80</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>-90,029,462.37</b>	<b>96,767,866.80</b>

### 2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
С08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,476.83	1,672,951,700.24	3,251,857,777.49

D01	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,476.83	1,672,951,700.24	3,251,857,777.49
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,476.83	1,672,951,696.24	3,251,857,773.49
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	04.00	00.00	04.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	96,767,866.80	96,767,866.80
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	541,754,600.42	1,037,151,480.83	1,769,719,563.04	3,348,625,644.29

#### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>1,250,307,503.00</b>	<b>1,992,384,937.25</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>104,563,010.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>00.00</b>	<b>5,995,900.00</b>
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	5,995,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,595,900.00
<b>122</b>	<b>Тусламжийн орлого</b>	<b>00.00</b>	<b>98,567,110.00</b>
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	98,567,110.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1,250,307,503.00</b>	<b>1,887,821,927.25</b>
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,160,272,800.00	1,525,502,400.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>36,913,543.00</b>	<b>00.00</b>
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	8,000,000.00	00.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	24,759,943.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,153,600.00	00.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>52,160,400.00</b>	<b>362,319,527.25</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	52,160,400.00	362,319,527.25
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	<b>960,760.00</b>	<b>00.00</b>
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	960,760.00	00.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>1,250,307,503.00</b>	<b>1,991,416,814.85</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,250,307,503.00</b>	<b>1,991,416,814.85</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,188,985,013.97</b>	<b>1,902,374,714.85</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>920,753,277.77</b>	<b>1,114,426,224.85</b>
210101	Үндсэн цалин	727,480,957.58	781,816,602.35
210102	Нэмэгдэл	167,512,716.19	268,752,072.07
210104	Урамшуулал	25,759,604.00	63,857,550.43
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>124,317,100.00</b>	<b>139,761,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	87,482,500.00	95,037,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	9,208,500.00	11,095,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,986,600.00	9,030,200.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,222,100.00	2,236,200.00

210205	Эрүүл мэндийн даатгал	18,417,400.00	22,361,800.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	47,442,106.20	312,606,200.00
210301	Гэрэл, цахилгаан	5,963,206.20	9,869,100.00
210302	Түлш, халаалт	40,908,900.00	302,226,500.00
210303	Цэвэр, бохир ус	570,000.00	510,600.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,259,637.00	00.00
210401	Бичиг хэрэг	1,053,022.00	00.00
210402	Тээвэр, шатахуун	2,946,540.00	00.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	726,100.00	00.00
210404	Ном, хэвлэл	400,400.00	00.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,539,975.00	00.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,593,600.00	00.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	44,913,244.00	104,608,340.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	746,400.00	00.00
210502	Хоол, хүнс	41,831,644.00	104,608,340.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,335,200.00	00.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	1,412,400.00	4,412,400.00
210604	Урсгал засвар	1,412,400.00	4,412,400.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	354,000.00	00.00
210702	Дотоод албан томилолт	354,000.00	00.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	8,720,000.00	112,500,810.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	8,000,000.00	102,163,010.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	720,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	10,337,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	32,813,249.00	114,059,540.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,524,349.00	98,501,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,288,900.00	15,557,900.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>61,322,489.03</b>	<b>89,042,100.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	51,218,034.00	89,042,100.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	960,760.00	00.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	32,033,150.00	68,816,800.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	18,224,124.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	20,225,300.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	6,198,561.23	00.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	6,198,561.23	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	3,905,893.80	00.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	3,905,893.80	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>00.00</b>	<b>968,122.40</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>00.00</b>	<b>968,122.40</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>00.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>00.00</b>	<b>968,122.40</b>

## 2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	1,859,621,900.00	1,629,097,287.60
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	1,859,621,900.00	1,629,097,287.60
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1,775,855,900.00	1,540,055,187.60
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1,129,428,800.00	1,074,468,197.60
210101	Үндсэн цалин	873,741,500.00	747,391,030.48
210102	Нэмэгдэл	228,839,300.00	266,966,992.69
210103	Унаа хоолны хөнгөлөлт	26,848,000.00	00.00
210104	Урамшуулал	00.00	60,110,174.43
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	141,168,600.00	134,418,300.00
210201	Тэтгэврийн даатгал	95,994,500.00	91,404,500.00
210202	Тэтгэмжийн даатгал	11,185,600.00	10,753,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,142,800.00	8,602,700.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,258,700.00	2,150,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	22,587,000.00	21,506,900.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	314,078,500.00	00.00
210301	Гэрэл, цахилгаан	9,869,100.00	00.00
210302	Түлш, халаалт	302,227,000.00	00.00
210303	Цэвэр, бохир ус	570,000.00	00.00
210304	Байрны түрээс	1,412,400.00	00.00
2105	<b>Нормативт зардал</b>	84,979,400.00	104,608,340.00
210502	Хоол, хүнс	84,979,400.00	104,608,340.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	13,971,900.00	112,500,810.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,600,000.00	102,163,010.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,371,900.00	10,337,800.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	92228700.00	114059540.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	76,670,800.00	98,501,640.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,557,900.00	15,557,900.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	83766000.00	89042100.00
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	83,766,000.00	89,042,100.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	83,766,000.00	68,816,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	20,225,300.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	00.00	1,630,065,410.00
1310	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	00.00	1,525,502,400.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	00.00	1,525,502,400.00
120004	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	00.00	5,995,900.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	2,400,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	3,595,900.00
122	<b>ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ</b>	00.00	98,567,110.00
122001	Хандив тусламж /дотоод/	00.00	98,567,110.00
5	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	968,122.40
62	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	1,020.00	58,301.00
620001	Удирдах ажилтан	555.00	7,878.00

620002	Гүйцэтгэх ажилтан	455.00	4,545.00
620003	Үйлчлэх ажилтан	10.00	45,878.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Үенч сумын сургууль нь 2021-2022 оны хичээлийн жилд Эрүүл чийрэг, эрдэм боловсролтой, хариуцлагатай бие даан суралцах, амьдрах чадвартай иргэн төлөвшүүлнэ гэсэн зорилготойгоор 77 ажилтан албан хаагчидтай үйл ажиллагаагаа явуулсан байна.

Танхимаар тасралтгүй 33-34 долоо хоног хичээллэж, сургуульд суурилсан үнэлгээ улсын хэмжээнд анх удаа хийгдэж 16 багшийн заасан хичээл I-III түвшинд үнэлэгдэж сарын 10%-25% урамшуулал авсан мөн байгууллагын үнэлгээгээр III түвшинд үнэлэгдэж багш ажилчид болон сургуулийн үйл ажиллагаанд урамшуулал авсан байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллага нь үйл ажиллагаандаа Бага дунд боловсролын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- “Хувьсах зардлын дундаж норматив тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоол;
- “Хичээл, сургалтын үйл ажиллагаа, Багшийн тасралтгүй хөгжил, цахим хэрэглээ, тоног төхөөрөмж нөхөн хангалт батлах тухай” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/170 дугаар тушаал;
- “Ерөнхий боловсролын сургуульд кабинет, лаборатори, цахим сургалтын танхим байгуулах, ашиглах тухай журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/465 дугаар тушаал;
- “Төрийн болон орон нутгийн өмчийн сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн чанар үр дүн үнэлж, үр дүнгийн урамшуулал олгох журам” Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/500 дугаар тушаал тус тус шинэчлэгдэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын ажилтан томилсон, дотоод хяналтын баг өдөр тутмын үйл ажиллагаандаа хяналт хэрэгжүүлж ажилладаг байна. Иймд дотоод хяналтын хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж дүгнэлээ.

Тайлант онд БШУЯ-ны дотоод аудитын алба болон аймгийн ЗДТГ-ын Санхүү, дотоод аудитын албанаас тус сургуулийн 2022 оны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Тус сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2020 онд баталсан бөгөөд шинээр батлагдсан холбогдох хууль, дүрэм, журам, заавар аргачлалын дагуу

өөрчлөлтийг тусгасан байгаа нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого ба толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Үенч сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 97,8 сая төгрөгөөр буюу 3.0 хувиар өссөн байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансдын үлдэгдэлд өөрчлөлт орсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/сая төгрөг/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	-	0,968	0,968
Авлага	13,518,2	7,589,2	-5,928,9
Бараа материал	39,592,7	32,142,6	-7,450,1
Үндсэн хөрөнгө	3,198,746,8	3,308,965,9	110,219,1
<b>Нийт хөрөнгө</b>	<b>3,251,857,7</b>	<b>3,349,666,0</b>	<b>-97,808,2</b>
Өр төлбөр	-	-	-
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	3,251,857,7	3,348,625,6	96,767,8
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>3,251,857,7</b>	<b>3,349,666,0</b>	<b>97,808,2</b>

Дансны үлдэгдэлд гарсан дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- ✓ Сангийн яамны 2022 оны 12 дугаар сарын 25 өдрийн 18 дугаартай албан бичгээр хүргүүлсэн чиглэлийн дагуу мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 0.9 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.
- ✓ Авлагын эхний үлдэгдэл 7.5 сая төгрөг байсан нь тайлант хугацаанд бүрэн барагдсан байна. Бодь Электроникс ХХК-с 6.7 сая төгрөгийн утасгүй интернэтийн төхөөрөмж 4 ширхгийг захиалж 12 сард мөнгөө шилжүүлж үндсэн хөрөнгөө аваагүй тул авлагаар бүртгэсэн
- ✓ "Техно Зон", "Ай ти зон", "ЕСМ ХХК" "Багшийн туслах" зэрэг компаниудаас 63,7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, программ хангамжийн худалдан авалтыг хийж, НББ-д тусгасан байна. Мөн Сумын ИТХ 2022 оны 03 сарын 18 ны өдрийн 8/13 тоот тогтоолын дагуу 22,1 сая төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил тус бүрийг акталж бүртгэлээс хассан байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллага 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 1,525.5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 362.3 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 3.5 сая төгрөг, зарлагыг 1,495.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Боловсролын салбар нь үр дүн гүйцэтгэлд суурилсан төсвөөр төсвөө боловсруулснаар нийт зардлыг 81.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна. Тайлант оны батлагдсан төсвийг 259.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 11 хөтөлбөрийн 22 арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,525,5 сая төгрөгийг улсын төсвөөс, 362,3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,9 сая төгрөгийг үйл ажиллагааны орлогоор бүрдүүлэхээр баталжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,525,5 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 362,3 сая төгрөг, үйл ажиллагааны орлогоос 5,9 сая төгрөг, нийт 1,893,8 сая төгрөгийн санхүүжилтийг бүрдүүлж, орон нутгийн төсөвт 0.2 сая төгрөгийг төвлөрүүлэн, 0,9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэлтэй байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,618.0 сая төгрөг буюу 99 хувьтай байгаа нь цалин, НДШ-ийн зардлыг 0,9 сая төгрөгөөр, бусад урсгал шилжүүлгийн зардлыг 0.01 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80226	Байр ажиглалтын үйлчилгээ	4,8	4,8	0	100%
80111	Барилгын тогтмол зардал	317,07	317,01	0	99,9%
80113	Нийтлэг үйлчилгээ	48,0	45,3	3,3	94,3%
80312	Сургалт семинар	2,07	2,06	0	99,6%
81605	Эрүүл мэндийг дэмжих	4,7	4,7	0	100%
81801	Үдийн цай хөтөлбөр	83,7	83,7	0	100%
81806	Дотуур байрны үйлчилгээ	123,8	123,8	0	100%
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	55,4	55,3	0,2	99,8%
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх	9,3	9,3	0	100%
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр	1,112,9	1,112,0	0,9	99,9%
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах	129,0	129,0	0	100%
81844	Гүнзгийрүүлсэн болон сургалтын орчныг сайжруулах	2,4	2,4	0	100%
81848	Сурах бичгийн түрээс	3,5	3,5	0	100%
	<b>дүн</b>	<b>1,896.6</b>	<b>1,892.8</b>	<b>3,8</b>	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Ховд аймгийн Үенч сумын сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хоо өрлөгийн үрс аудит ХХК-ны аудитор А.Оюундэлгэр гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар хэрэгжүүлсэн.

Ховд аймгийн Үенч сумын сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 04 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “бага” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт орлогын 1281.9 сая төгрөгөөс 2 хувиар 25,6 сая төгрөгөөр тогтоосон. Гүйцэтгэлийн шатанд 2022 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 2166.6 сая төгрөгөөр 2 хувиар буюу 43.3 сая төгрөгөөр тогтоож, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 80 хувиар тооцон 34.6 сая төгрөгөөр дахин хянаж шинэчлэн тогтоосон болно.

#### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардлуудыг санхүүжүүлээгүй байна.

#### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд тендэрт шалгарсан оролцогчийн мэдээлэл, таван саяас дээш орлого, зарлагын гүйлгээг болон тушаал шийдвэрийн 157 мэдээ оруулахаас 11 мэдээ хугацаа хоцорч 146 мэдээ хугацаандаа бүрэн орж хуулийн хэрэгжилт 93.9 хувьтай байна.

##### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг шалгаж бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн бараа ажил үйлчилгээний төлбөрийн дүн татварын нэвтрэлтийн нэгдсэн системд бүртгээгүй 21.7 сая төгрөгийн гүйлгээ хийсэн байна. Аудитын явцад гүйлгээг нөхөн шивүүлж, зөрчлийг арилгасан.

#### 4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар "Хязгаарлалттай" санал дүгнэлт авч аудитаар 215.0 сая төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 0.1 сая төгрөгийн 1 залруулга, алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 214.9 сая төгрөгийн 5 зөвлөмж өгсөн. Аудитын шийдвэрийн нийт биелэлт 100.0 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилт

Үзүүлэлт	Илрүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	5	214.9	5	214.9	100.0
<b>Нийт дүн</b>	<b>5</b>	<b>214.9</b>	<b>5</b>	<b>214.9</b>	<b>100.0</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар оны эцэст салбарын зохион байгуулдаг худалдан авах ажиллагаа, хөрөнгө оруулалтаар ирсэн хөрөнгийн хэрэгцээ шаардлагыг анхаарч үзэх шаардлагатай гэж үзлээ.

### 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 118.6 сая төгрөгийн алдаа<sup>1</sup>, нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хэрэгжилтийг дутуу хангасан, ойн хандивын орлогыг бүртгээгүй зэрэг алдаа илэрлээ. Үүнд:

5.1 Мөнгөн хөрөнгийн журналыг тайлангийн санхүүжилттэй тулган шалгахад сургуулийн ой тэмдэглэн бэлнээр хандив өргөсөн орлогыг харилцах дансаар дамжуулаагүй бэлнээр хүлээн авсан зөрчил 95567.1 мянган төгрөгийн хандив, ХАОАТ-ын өглөгийг 1199.5 төгрөгөөр илүү тусгасан, ҮЭ татварын 230.0 төгрөгийг өглөгт тусгаагүй нийтдээ 96,996.7 мянган төгрөг нь Төсвийн тухай хуулийн 6.3.4.төсвийн жилийн явцад шинээр бий болсон аливаа орлого, эх үүсвэр, зээл, хандив, тусламж, тэдгээрээр санхүүжүүлсэн үйл ажиллагааны зарлага нь төсвийн бүрэлдэхүүн байх, 25.7.Тусламж, хандивын орлогыг холбогдох журмын дагуу бүртгэж, гүйцэтгэлийг тайлагнах, Нягтлан бодох бүртгэлийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэсэн заалтыг үндэслэн залруулга хийв.

5.2 *Баланс эх үүсвэрээрээ 4000.0 мянган төгрөг, Цалин хөлсний дэлгэрэнгүй бүртгэлийн тооцсон цалин үр дүнгийн тайлангийн өртөгт суусан цалингаас 17600.0 мянган төгрөгөөр зөрж санхүүгийн программын алдаа илэрсэн Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15.2.Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна гэсэн заалтыг үндэслэн залруулга хийв.*

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

#### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Хандивын орлого тайланд тусгах, өр авлагын тооцоог үнэн зөв хийх, програмын алдааг засуулах	2	118,6			2	118,6	2	118,6				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>118,6</b>			<b>2</b>	<b>118,6</b>	<b>2</b>	<b>118,6</b>				

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЯДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  А.ОЮУНДЭЛГЭР

<sup>1</sup> Тайлагнасан санхүүгийн тайлангийн үзүүлэлт, тайлагнасан байвал зохих үзүүлэлтийн хоорондын зөрүү. Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.